**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баянхонгор сумын Шаргалжуут багийн ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2023/13/НА-СТА-ТШ3**

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2023 оны 02 дугээр сарын 17


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Н.Бүнчинсүрэн

Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА..... 10
4. АУДИТЫН ТАЙЛАН..... 14
4.1 Ерөнхий зүйл ..... 14
4.2 Материаллаг байдал ..... 14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт..... 15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 16
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... 16
5.3. Зөвлөмж..... 16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/64

танай ______________ -ны № ________________ -т

БАЯНХОНГОР СУМЫН ШАРГАЛЖУУТ
БАГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Н.АМАРСАНАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Шаргалжуут багийн ЕБС-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Шаргалжуут багийн ЕБС-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллага багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардлаас 700.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

005020290
D/2023-A4 Alban toot

**Бусад асуудлын хэсэг**

Баянхонгор сумын Шаргалжуут багийн ЕБС нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 97 хувиар үнэлсэн байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Баянхонгор сумын Шаргалжуут багийн ЕБС нь 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

D/2023-A4 Alban toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан** /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **58,838,776.60** | **115,677,546.85** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 80,092,418.85 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 80,092,418.85 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 80,092,418.85 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 80,092,418.85 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 58,838,776.60 | 35,585,128.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 58,838,776.60 | 35,585,128.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 598,500.00 | 100,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,051,500.00 | 574,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 450,000.00 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,524.00 | 3,245.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 54,735,252.60 | 34,907,383.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **477,929,607.56** | **451,589,622.27** |
| **39** | **ҮНДСЭНХӨРӨНГӨ** | 477,929,607.56 | 451,589,622.27 |
| **392** | **Биет хөрөнгө** | 467,073,607.56 | 440,733,622.27 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 454,391,414.55 | 454,391,414.55 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -86,479,738.77 | -114,461,874.40 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 34,308,176.00 | 56,335,976.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -10,774,960.64 | -18,980,782.38 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 75,178,926.80 | 79,308,016.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -24,238,245.39 | -36,124,020.84 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 69,712,430.30 | 69,712,430.30 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -62,680,463.64 | -68,244,295.51 |
| 39217 | Ном | 17,656,068.35 | 18,796,757.75 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 10,856,000.00 | 10,856,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 10,856,000.00 | 10,856,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **536,768,384.16** | **567,267,169.12** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **536,768,384.16** | **567,267,169.12** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 536,768,384.16 | 567,267,169.12 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 434,535,590.06 | 434,535,590.06 |
| 51101 | Өмч: - төрийн | 434,535,590.06 | |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 0 | 434,535,590.06 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -147,092,672.03 | -116,593,887.07 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -147,092,672.03 | -147,092,672.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 30,498,784.96 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 249,325,466.13 | 249,325,466.13 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **536,768,384.16** | **567,267,169.12** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **511,603,598.13** | **620,745,179.40** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,138,495.00** | **20,506,579.40** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 8,138,495.00 | 20,506,579.40 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 401,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 401,000.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ | 6,919,170.00 | 20,105,579.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ | 1,219,325.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **455,929,906.00** | **600,238,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 408,007,100.00 | 529,914,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 529,914,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 408,007,100.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 47,922,806.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 47,922,806.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 47,535,197.13 | 70,324,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 47,535,197.13 | 70,324,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **543,972,734.07** | **590,246,394.44** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **543,972,734.07** | **590,246,394.44** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 466,992,287.05 | 568,709,820.44 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 303,189,965.00 | 360,741,917.00 |
| 210101 | Үндсэн цалин | 261,467,040.00 | 252,732,972.00 |
| 210102 | Нэмэгдэл | 19,482,056.00 | 75,388,246.00 |
| 210104 | Урамшуулал | 22,240,869.00 | 14,494,299.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 18,126,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,370,644.98 | 45,811,734.15 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,831,863.94 | 32,503,398.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,940,856.54 | 2,836,865.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,437,154.62 | 2,641,383.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 490,771.42 | 835,450.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,669,998.46 | 6,994,636.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 43,535,907.13 | 48,046,576.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,742,795.13 | 3,941,076.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,073,112.00 | 43,811,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 720,000.00 | 294,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,594,958.00 | 35,954,469.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,703,309.00 | 4,751,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 998,580.00 | 1,010,880.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 144,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 150,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,888,870.00 | 8,995,070.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,860,199.00 | 21,046,869.60 |
| **2105** | **Нормативт зардал** | 7,363,088.00 | 18,423,059.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,363,088.00 | 18,423,059.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,257,710.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,257,710.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 248,700.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 248,700.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 793,000.00 | 1,534,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 443,000.00 | 401,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,133,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 54,638,313.94 | 58,198,064.69 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 3,987,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 173,500.00 | 573,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 54,464,813.94 | 53,637,564.69 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 76,980,447.02 | 21,536,574.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 53,008,697.00 | 20,547,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,692,500.00 | 20,547,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 39,023,547.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 4,533,650.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 759,000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 989,574.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 989,574.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 23,971,750.02 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23,971,750.02 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-32,369,135.94** | **30,498,784.96** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,420,027.89 | 00.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 1,420,027.89 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -1,420,027.89 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-33,789,163.83** | **30,498,784.96** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **503,465,103.13** | **600,639,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **401,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 401,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 401,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 401,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **503,465,103.13** | **600,238,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 408,007,100.00 | 529,914,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 529,914,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 408,007,100.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 47,922,806.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 47,922,806.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 47,535,197.13 | 70,324,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 47,535,197.13 | 70,324,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **495,125,103.13** | **513,355,181.15** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **495,125,103.13** | **513,355,181.15** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **419,620,756.11** | **491,818,607.15** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 302,843,397.98 | 360,741,917.00 |
| 210101 | Үндсэн цалин | 227,144,097.00 | 252,732,972.00 |
| 210102 | Нэмэгдэл | 51,475,312.98 | 75,388,246.00 |
| 210104 | Урамшуулал | 24,223,988.00 | 14,494,299.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 18,126,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,717,212.00 | 45,811,734.15 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,918,524.28 | 32,503,398.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,449,596.93 | 2,836,865.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,959,897.54 | 2,641,383.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 489,899.39 | 835,450.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,899,293.86 | 6,994,636.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 43,535,907.13 | 48,046,576.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,742,795.13 | 3,941,076.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,073,112.00 | 43,811,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 720,000.00 | 294,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,343,440.00 | 00.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 997,900.00 | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 998,580.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 144,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,202,960.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 12,073,200.00 | 18,590,780.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25,000.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,766,700.00 | 18,590,780.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,281,500.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,940,490.00 | 895,150.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,940,490.00 | 895,150.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 248,700.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 248,700.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,858,609.00 | 1,534,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,508,609.00 | 401,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,133,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,059,800.00 | 16,198,450.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,100,000.00 | 11,104,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 959,800.00 | 5,093,950.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **75,504,347.02** | **21,536,574.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 51,532,597.00 | 20,547,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 7,216,400.00 | 20,547,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 39,023,547.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 4,533,650.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 759,000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 989,574.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 989,574.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 23,971,750.02 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23,971,750.02 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **8,340,000.00** | **87,284,418.85** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **8,340,000.00** | **7,192,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **8,340,000.00** | **7,192,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 8,340,000.00 | 7,192,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 8,340,000.00 | 7,192,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-8,340,000.00** | **-7,192,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 80,092,418.85 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 80,092,418.85 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 434,535,590.06 | 249,325,466.13 | -113,303,508.20 | 570,557,547.99 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -33,789,163.83 | -33,789,163.83 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **434,535,590.06** | **249,325,466.13** | **-147,092,672.03** | **536,768,384.16** |
| D01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **434,535,590.06** | **249,325,466.13** | **-147,092,672.03** | **536,768,384.16** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | **434,535,590.06** | **249,325,466.13** | **-147,092,672.03** | 536,768,384.16 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **434,535,590.06** | **249,325,466.13** | **-147,092,672.03** | 536,768,384.16 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 30,498,784.96 | 30,498,784.96 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **434,535,590.06** | **249,325,466.13** | **-116,593,887.07** | 567,267,169.12 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** / төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 600,788,800.00 | 519,557,607.15 | 81,231,192.85 | 86.5 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 600,788,800.00 | 519,557,607.15 | 81,231,192.85 | 86.5 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 579,168,100.00 | 499,010,607.15 | 80,157,492.85 | 86.2 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 421,872,100.00 | 360,741,917.00 | 61,130,183.00 | 85.5 |
| 210101 | Үндсэн цалин | 296,393,100.00 | 252,732,972.00 | 43,660,128.00 | 85.3 |
| 210102 | Нэмэгдэл | 93,172,200.00 | 75,388,246.00 | 17,783,954.00 | 80.9 |
| 210104 | Урамшуулал | 14,180,400.00 | 14,494,299.00 | -313,899.00 | 102.2 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 18,126,400.00 | 18,126,400.00 | 0.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 52,734,600.00 | 45,811,734.15 | 6,922,865.85 | 86.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,859,100.00 | 32,503,398.86 | 3,355,701.14 | 90.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,218,700.00 | 2,836,865.28 | 1,381,834.72 | 67.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,374,900.00 | 2,641,383.21 | 733,516.79 | 78.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 843,800.00 | 835,450.32 | 8,349.68 | 99.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,438,100.00 | 6,994,636.48 | 1,443,463.52 | 82.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48,931,300.00 | 48,046,576.00 | 884,724.00 | 98.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,220,000.00 | 3,941,076.00 | 278,924.00 | 93.4 |
| 210302 | Түлш, халаалт | 43,811,300.00 | 43,811,300.00 | 0.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 900,000.00 | 294,200.00 | 605,800.00 | 32.7 |
| **2105** | **Нормативт зардал** | 25,390,400.00 | 18,590,780.00 | 6,799,620.00 | 73.2 |
| 210502 | Хоол, хүнс | 25,390,400.00 | 18,590,780.00 | 6,799,620.00 | 73.2 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 895,150.00 | 104,850.00 | 89.5 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 895,150.00 | 104,850.00 | 89.5 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,934,400.00 | 1,534,000.00 | 2,400,400.00 | 39.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 550,200.00 | 401,000.00 | 149,200.00 | 72.9 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,384,200.00 | 1,133,000.00 | 2,251,200.00 | 33.5 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 25305300.00 | 23390450.00 | 1,914,850.00 | 92.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,944,800.00 | 18,296,500.00 | 1,648,300.00 | 91.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,360,500.00 | 5,093,950.00 | 266,550.00 | 95.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 21620700.00 | 20547000.00 | 1,073,700.00 | 95.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 21,620,700.00 | 20,547,000.00 | 1,073,700.00 | 95.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,620,700.00 | 20,547,000.00 | 1,073,700.00 | 95.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 600,788,800.00 | 599,650,026.00 | 1,138,774.00 | 99.8 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 529,914,300.00 | 529,914,300.00 | 0.00 | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 529,914,300.00 | 529,914,300.00 | 0.00 | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 70,324,300.00 | 69,334,726.00 | 989,574.00 | 98.6 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 550,200.00 | 401,000.00 | 149,200.00 | 72.9 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 550,200.00 | 401,000.00 | 149,200.00 | 72.9 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 80,092,418.85 | -80,092,418.85 | #DIV/0! |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 30 | 30 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18 | 18 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 11 | 11 | 0.00 | 100.0 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 171 | 171 | 0.00 | 100.0 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 170 | 170 | 0.00 | 100.0 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 170 | 170 | 0.00 | 100.0 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **30** | **30** | 0.00 | 100.0 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 15 | 15 | 0.00 | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 15 | 15 | 0.00 | 100.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн Ерөнхий боловсролын сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Эх хэлээр алдаагүй зөв цэвэр сайхан бичдэг, өөрийгөө илэрхийлэх чадвартай, мэндлэх, хүндлэх ёсыг дээдэлдэг цэвэр нямбай хүүхэд төлөвшүүлнэ” гэсэн зорилготой ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын алба байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийн аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг бөгөөд Баянхонгор сумын Шаргалжуут багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Шаргалжуут багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор сумын Шаргалжуут багийн Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2021 оны 12 сарын 14 өдрийн А/37 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Шаргалжуут багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор сумын Шаргалжуут багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 567,267.2 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 30,498.8 мянган төгрөгөөр буюу 5.7 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 80,092.4 | 80,092.4 |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 58,838.8 | 35,585.1 | (23,253.6) |
| Үндсэн хөрөнгө | 662,103.0 | 689,400.6 | 27,297.6 |
| Хуримтлагдсан элэгдэл | (184,173.4) | (237,811.0) | (53,637.6) |
| **Нийт хөрөнгө** | **536,768.4** | **567,267.2** | **30,498.8** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 536,768.4 | 567,267.2 | 30,498.8 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **536,768.4** | **567,267.2** | **30,498.8** |

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд үлдэгдэлгүй байсан бөгөөд тайлант оны эцэст улсын төсвийн санхүүжилтийн үлдэгдэл 80,092.4 мянган төгрөг үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 35,585.1 мянган төгрөг болж өмнөх оноос 23,253.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 51,158.9 мянган төгрөгийн хөрөнгө орлого авч, 53,365.7 мянган төгрөгийн төгрөгийн бараа материалыг зарцуулж, 21,046.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой бөгөөд үүнээс бусад хангамжийн материал 19,827.9 мянга, аж ахуйн материал 2,477.0 мянган төгрөгөөр буурсан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 689,400.6 мянган төгрөг болж 27,297.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 7,192.0 мянга, БШУЯ-аас 18,912.6 мянга, НҮБ-ийн хүүхдийн ивээх сангаас 1,193.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 567,267.2 мянган төгрөг болж 30,498.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 30,498.8 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 696,630.0 мянган төгрөг авч зарцуулахаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 130417.9 мянган төгрөгөөр бууруулж 566,212.1 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 600,788.8 мянган төгрөг болгож 34,576.7 мянган төгрөгөөр өсгөн баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 хөтөлбөрийн 80226, 80312, 81605, 81816, 81823, 81834, 81835, 80112 арга хэмжээг санхүүжүүлэхээр 600,788.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 530,464.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 70,324.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 530,464.5 мянга, орон нутгийн төсвөөс 70,324.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй орон нутгийн төсвийн санхүүжилтээс 989.6 мянган төгрөгийг буцаан орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 519,557.6 мянган төгрөг буюу 86.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 81,231.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | **71802 Ерөнхий боловсрол** | **600,788.8** | **519,557.6** | **81,231.2** | 86.5 |
| 2 | 80226 Байр аиглалтын зардал | 877.0 | 877.0 | 0.0 | 100.0 |
| 3 | 80312 Сургалт семинарын зардал | 438.5 | | 438.5 | 0.0 |
| 4 | 81605 Эрүүл мэндийг дэмжих зардал | 1,531.6 | 1,452.5 | 79.1 | 94.8 |
| 5 | 81801 Үдийн цай хөтөлбөр | 21,620.7 | 20,547.0 | 1,073.7 | 95.0 |
| 6 | 81806 Дотуур байрны үйлчилгээ | 41,650.5 | 34,402.7 | 7,247.8 | 82.6 |
| 7 | 81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 7,495.0 | 7,192.0 | 303.0 | 96.0 |
| 8 | 81823 Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх | 3,087.7 | 2,260.0 | 827.7 | 73.2 |
| 9 | 81834 Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 412,905.9 | 344,255.1 | 68,650.8 | 83.4 |
| 10 | 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 40,307.4 | 38,835.6 | 1,471.8 | 96.3 |
| 11 | 81848 Сурах бичгийн түрээсийн зардал | 550.2 | 401.0 | 149.2 | 72.9 |
| 12 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 70,324.3 | 69,334.7 | 989.6 | 98.6 |
| | **Нийт дүн** | **600,788.8** | **519,557.6** | **81,231.2** | 86.5 |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн

тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд гүйлгээ хийгээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор сумын Шаргалжуут багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Шаргалжуут багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дүгээр сарын 20-ны өдрийн 49 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор сумын Шаргалжуут багийн Ерөнхий боловсролын сургуулийн захирал Н.Амарсанаа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Одгэрэл нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 600,788.8 мянган төгрөгөөс тооцоход 9,011.8 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 6,308.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь шилэн дансанд мэдээлбэл зохих 615,392.5 мянган төгрөгийн 151 мэдээллээс 148 мэдээлэл хугацаандаа оруулж аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан бүтэн жилээр мэдээлэх 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Харин Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) мэдээлэх хэсэгт 43,811.3 мянган төгрөгийн халаалт, 37,484.8 мянган хүнсний материалын гэрээг мэдээлээгүй байна.

*Хүснэгт 3. Шилэн дансны мэдээлэл*

| д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 8 | 1 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 96 | 0 | |
| | Нийт | 27 | 151 | 148 | 1 | 2 |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, тендерийн худалдан ажиллагааны мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 10,157.3 мянган төгрөгийн 2 зөрчлийг давтан гаргахгүй байх 2 заалт бүхий зөвлөмж өгсөн ба Баянхонгор сумын Шаргалжуут багийн Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2022.05.25-ны өдрийн 45 дүгээр албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Зөвлөмж | 2 | 10,157.3 | 2 | 10,157.3 | 100 |
| **Нийт дүн** | 2 | 10,157.3 | 2 | 10,157.3 | 100 |

Эх сурвалж: 2021 оны аудитын тайлангаас

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх"-ыг БСШУСС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 оны 1, 2 дугаар саруудад бүрэн ажиллаагүй, хоолны ирцэд хяналт тавьснаар хоолны зардал 6799.6 мянга, Үдийн цай хөтөлбөрийн зардал 1073.7 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 700.0 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 700.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүллээ.

### 5.3. Зөвлөмж

1. Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2022.05.30-ны өдрийн 218 тоот албан бичгийн дагуу Ерөнхий боловсролын сургуулиудын орос хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах албан бичиг ирсний дагуу англи хэл, орос хэлний багш Ч.Ганчимэг, сургуулийн захирал Н.Амарсанаа нарын замын зардлын 700.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022.05.12-ны өдрийн А/170 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт түүнийг зарцуулах заавар"-ын 5.2.2-т "Туршлага судлах зорилготой дотоод болон гадаадад аялал зохион байгуулах"-ыг санхүүжүүлэхгүй гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж**: Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих зардлыг зориулалтын дагуу зарцуулж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардлаас гадаад явах замын зардлын 700.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 700.0 | | | | | 1 | 700.0 | | | | |
| Дүн | 1 | 700.0 | | | | | 1 | 700.0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) мэдээлэх хэсэгт 43,811.3 мянган төгрөгийн халаалт, 37,484.8 мянган хүнсний материалын гэрээг мэдээлээгүй байна. | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |
| Дүн | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |

ooOoo